



**“ГУРВАН ҮСГИЙН СУДАР” ЗОХИОЛЫН АГУУЛГА БОЛОН
ОРЧУУЛГЫН ОНЦЛОГ**

П.Уянга⁸, Б.Нэргүйжаргал⁹

Товч утга: Хүн төрөлхтний оюун санааны амьдралд гарсан нэгэн том ололт бол хойч үеэ сурсан хүмүүжүүлэх арга зарчмуудыг тодорхойлон гаргаж ирсэн явдал юм. Энэ нь өнөөг хүртэл урт удаан хугацааны туршид улам хөгжин боловсронгуй болсоор байгаа билээ.

Күнз, Сүнз, Мэнз, Лаоз, Жуанз, Гаоз зэрэг эртний гүн ухаантнууд хятад хүний ёс зүй, амьдрах ухаан, ертөнцийг үзэх үзэл, ойлголтын эх үндсийг тавьсан бөгөөд тэд “Зуун овог” /百家姓/, “Мянган үсгийн соёл” /千字文/, “Гурван үсгийн судар” /三字经/, “Дөрвөн бичиг” /四书/, “Таван ном” /五经/ гээд олон ном судар туурвисан нь одоо хэр хятадын сэтгэхүй, харилцааны суурь дэвсгэр болдог аж.

Гэрийн сургуулийн хичээлийн хэрэглэгдэхүүн “Гурван үсгийн судар” зохиолын агуулгыг сурах—журмыг мэдэх—ачлах гэсэн зарчмаар томъёолж болох юм. Өөрөөр хэлбэл гэрийн сургуулиар олгох сургалт хүмүүжил нь хүнийг жинхэнэ хүн болгох зарчимд тулгуурлаж байжээ гэсэн үг юм.

Энэхүү зохиол нь 3 үсэгтэй шүлгийн хэлбэрээр бичигдсэн учир унших, цээжлэхэд хялбар, товч бөгөөд хүүхдэд боловсрол олгоход чиглэсэн тул дэлхийн олон орны судлаачдын сонирхлыг татаж Англи, Франц, Орос, Япон, Солонгос, Монгол, Вьетнам, Герман, Испани зэрэг хэлнээ орчуулагдсан бөгөөд эдгээр орчуулга нь тухайн орны соёл, боловсролын онцлогтой уялдан орчуулагдсан байдаг.

Түлхүүр үг: судар, сургах, хүмүүжүүлэх, орчуулга, онцлог

Нэг. “Гурван үсгийн судар” зохиолын агуулгын тухай

Хятадын эртний гүн ухаантнууд “Зуун овог”, “Мянган үсгийн соёл”, “Гурван үсгийн судар”, “Дөрвөн бичиг”, “Таван ном” гээд олон судар туурвисан бөгөөд эдгээр нь цөм гэрийн сургуулийн анхлан үздэг үндсэн сурах бичиг билээ.

“Гурван үсгийн судар”¹⁰ зохиол нь хэдийгээр мянга гаруйхан үсэгтэй боловч тухайн үеийн феодал ангийнханд ихэд хүндлэгдэж байв. Чин улсын феодал ангийн ноёрхогчид: «Анхлан сургуульд орсон найман наснаас дооших хүүхэд» энэхүү судрыг заавал унших ёстой сурах бичиг болгож тогтоосон байдаг.

⁸ МУИС, ШУС, Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор

⁹ МУИС, ШУС, Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор

¹⁰ П.Уянга “Гурван үсгийн судар” УБ. 2019 он

“Гурван үсгийн судар” -т хүмүүний төрөлх шинж, сургах болон сурахын ач тус, юуг сурч мэдвээс зохих ертөнцийн үзэгдэл юмс зэргийг тодорхой дэс дараалалтайгаар гурав гурван ханз үсгээр тайлбарлан бичсэн байдаг. Уг судрын агуулгыг сурах, журмыг мэдэх, ачлах гэсэн зарчмаар томъёолж болох юм.

Энэхүү судар нь нийт 380 өгүүлбэртэй, 1140 ханз үсэгтэй, утгын хувьд үг хэллэг нь задран тайлбарлагдах “ухагдахуун” маягаар бичигдсэн, орчлонгийн эд юмс, байгалийн үзэгдэл, жам ёс, улс гүрний түүхэн товчоог суралцагчдад ойлгомжтой товч тодорхой дурдан бичсэн арвин баялаг агуулга бүхий ёслол журам, танин мэдэхүйн судар юм.

Энэхүү сударт сурган хүмүүжүүлэх асуудлыг авч үзэхдээ, хүний тархи бол цэвэр самбар юм. Хүүхдийн төрсөн цагаас эхлэн түүний үзэж харсан, сонсож мэдсэн бүхэн тэр самбарт бичигдэж амьдралынх нь туршлага болон ухаан нэмж байдаг гэсэн үзлийн үүднээс тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, зохиолд бичсэнээр: “Хүмүүн төрөхдөө мэргэн мунхаг, сайн олиггүйн чанар нэгэн адил бөгөөд гагцхүү сурч мэдсэнээр ухах хурдныг нь мэргэн, мэдэх харанхуйг нь мунхаг, ёсыг дагах нь сайн, хүслийг тавих нь олиггүй...” хэмээсэн байдаг.

“言人初生时，智愚贤不肖，皆同此性，本相近而无别也，及乎知识既开，气禀各异，资之敏者则为智...”¹¹

“Гурван үсгийн судар” зохиолын бас нэгэн онцлог нь танин мэдэхүйн асуудлыг орхилгүй орчлонгийн эд юмс, байгалийн үзэгдэл, жам ёс, улс гүрний түүхэн товчоог суралцагчдад ойлгомжтой товч тодорхой дурдан бичсэнд оршино.

Уг сударт хүмүүний сурган хүмүүжүүлэх асуудлыг тодорхой дэс дарааллаар гарган тавьсан нь чухал шинжтэй юм. Хүнийг сургах, хүмүүжүүлэх нь түүнийг бүрэлдэн бий болсон цагаас буюу эхийн хэвлийд байхаас нь эхэлдэг гэсэн байдаг. Энэ тухай сударт:

“古者妇人有娠，坐不偏、卧不侧、立不跛倚、行不乱步、目不视恶色，耳不听淫声，不出乱言、不食邪味、常行忠孝友爱慈良之事，往往生子聪明才智，贤德过人。此未生之胎教也。”

“Эртний эм бие шалтгаантай болсны хойно суухад хэлбийхгүй, хэвтэхэд хазайхгүй, зогсоход далжийж түшихгүй, явахад дэмий алхахгүй, нүдэнд муу өнгийг үзэхгүй, чихэнд хурьцангуй дууг сонсохгүй, самуун үгийг гаргахгүй, дэмий амттаныг идэхгүй, үргэлж шударга тахимдуу, элэгсэг, өршөөл асрал, сайн хэргээр явахын тул төрсөн хөвүүн цэцэн мэргэн, эрдэмт бөгөөд мэргэн эрдэмт хүнээс шалгарсан нь олон. Энэ нь төрөхийн урьд бие шалтгаантай болох цагаас сургасан нь болой” гэжээ. Ингэж төрөхийн урьдаас сурган хүмүүжүүлсээр төрсөн хойно сургах зарчмыг мөн тодорхойлсон байна. Үүнд:

“子能食·教以右手；能言·勿使娇声；能行·使知四方上下；能揖·教以礼让尊亲。”

“Хөвүүн идэж чадмагц баруун этгээдийн гарыг сургамуй, хэлж чадмагц эрхлэх дууг гаргахгүй болмуй, явж чадмагц дөрвөн зүг, дээд доордыг ухуулмуй, мэхэсхийж чадмагц ёслол, найр талбиу, эцэг эхээ эрхэмлэхүйг сургамуй.”

“此婴孩之幼习，母氏之教也，至于洒扫应对进退之节，礼乐射御书数之文此童子之初学父师之教。”

Энэ нь бага хөвгүүдийг багадаа боловсруулахуй нь эхийн сургаал болой. Жич, үсрэх шүүрдэх, нийлүүлэх өчих, орох эгэхийн хэмжээ, ёслол хөгжим, харвалгаа дэлбэлгээ, бичиг тооны

¹¹ 毛增印“三字经与中国民俗画” 五洲传播出版社，2005

утга хэмээгч нь бага хөвгүүдийн анхан дор сурахуй нь эцэг ба багшийн сургахуй нь болой гэсэн нь хүүхдийг сурган хүмүүжүүлэхэд эцэг ба эхийн үүрэг, нөлөө өөр өөр байхыг заахын зэрэгцээ биеийг төрүүлж, сэтгэлийг засаж хүмүүжүүлдэг эрхэм хүн бол ээж юм гэдгийг тодруулжээ. Жишээлбэл:

“Эрт цагт Мэнзийн эх суух газрыг сонгож нүүжхүй. Хөвгүүн эс сурахын учир бөс нэхэх салгамжийг хугалжухуй.”

“昔孟母，择邻处。子不学，断机杼。”

“Эрт цагт Мэнзийн эх Жан, Мэнзийг сургахын тулд гурвантаа нүүж, эцэстээ гэрийн сургуулийн хажууд очин, тус газрыг хөвгүүндээ ном бичиг уншуулан, ёслол сургах сайн газар гэж үзсэн байна. Мэнз нэг удаа сургуулиасаа зугтаан гэртээ эрт харьж ирсэнд эх нь бөс нэхэх салгамжаа хугалж хаяжээ. Чармайн эс суралцваас эрдэм чадвартан болж эс чадахуй нь бөс нэхэх салгамжийг хугалбаас, нэхэж эс чадахуй лугаа адил” хэмээхүйг хүүдээ тийнхүү сургасан байдаг.

“Үнэхээр эс сурваас чанар даруй шилжмүй. Сургахуйн ёсонд чин сэтгэл эрхэм буюу.”

“苟不教，性乃迁。教之道，贵以专。”

Энэ нь сурган хүмүүжүүлэх ёсны эрхэм зүйл нь чин үнэнч байхад оршино. Энэ нь хүүхдийг хүмүүжүүлэхийн зэрэгцээ сурч боловсрох, оюун билгийг нь хөгжүүлэхэд суралцагч болон сургагчийн өмнө тавьж буй шаардлага зарчим юм. Хэрвээ сургахгүй бол чанар нь даруй муу болмуй.

“Ус, гал, мод, төмөр, шороо хэмээхүй, энэ таван махбод тоог үндэс болгожухуй.”¹²

“曰火水，木金土。此五行，本乎数。”

Гал нь гялбан хийх, ус нь норгон шавших, мод нь сав зэвсэг бүтээх, төмөр нь хуяг зэвсэг хийх, шороо нь ургуулан тарих, хэрэм босгох гавьяатай болой. Тоог үндэс болгожухуй гэдэг нь зурхайчид таван махбодын харилцан үүсэл болон хувирал нь тооноос үүдэлтэй гэж үздэг.

“Баяр хилэн, гаслан айдас, хайр жигшил, хүсэл хэмээхүй, энэ долоон зүйл нь хүмүүний сэтгэл хөдлөл бөлгөө.”¹³

“曰喜怒，曰哀惧。爱恶欲，七情具。”

Сэтгэл санаа бол амьдралын эрч хүчийг нэмэгч, зовлон зүдүүрийг үүсгэгч хэмээх сургаал юм. Баярлах, хилэгнэх, гашуудах, айх эмээх, хайрлах, жигших, хүсэхүй нь хүний долоон зүйлийн сэтгэл хөдлөл юм.

“Эцэг хөвгүүн энэрэлтэй, эр эм эвтэй, ах болбоос элгэмсүү, дүү болбоос хүндлэлтэй, ахас нялхас зүйтэй, анд нөхөр сайн, эзэн болбоос хичээнгүй, түшмэл болбоос шударга, энэхүү арван журмыг хүмүүн цөм сахигтун.”

“父子恩，夫妇从；兄则友，弟则恭；长幼序，友与朋；君则敬，臣则忠；此十义，人所同。”

Арван журам гэдэг нь эцгийн энэрэл, хөвгүүний ачлал, ахын элэгсэг, дүүгийн дүүчлэл, эрийн журам, эхнэрийн үнэнч, ахсын тус, залуусын эв, эзний өршөөл, түшмэлийн шударга зэрэг болно. Энэ нь эцэг эх, ах дүү, эхнэр нөхрийн харилцаа, ёс журмыг зааж буй хэрэг юм.

Хоёр. “Гурван үсгийн судар” зохиолын орчуулгын онцлогийн тухай

“Гурван үсгийн судар” зохиолын уламжлагдаж ирсэн хэвлэл олон байдаг бөгөөд Мин улсын үед зарим хүмүүн нэмж засварлан тайлбар оруулсан гэлцдэг. Хожим Күнзийн шавь нар уг судрыг

¹² 毛增印“三字经与中国民俗画”五洲传播出版社，2005

орчуулан, тайлбар зүүлт оруулан, зураг хавсаргаж, аялгуу тааруулан айзам холбосон байна. Мин улсын сүүлч Чин улсын эхэн үед манж хятадаар болон монгол хятадаар хавсарсан “Гурван үсгийн судар” гарч байжээ. Энэхүү судрыг 1735 оны үед Тоо гүн манжаар орчуулан бичсэн бол 1832 оны үед Сун Янь /崧岩/¹⁴ монгол хэлээр орчуулан хадаж, тайлбар үлгэрийг хянан зассан гэдэг.

“Гурван үсгийн судар”-аас “Тоо гүний гурван үсгийн сургаал бичиг” нэрээр эрдэмтэн судлаач Х.Сампилдэндэв, Г.Эрдэнэ-Очир, Г.Ловор нар зохиол бүтээлдээ эшлэл авч тайлбарласан нь бий. Энэхүү зохиол нь дэлхийн олон орны сонирхлыг татаж Англи, Франц, Орос, Япон, Солонгос, Монгол, Вьетнам, Герман, Испани зэрэг хэлнээ орчуулагдсан байдаг.

Эдгээр орчуулга нь тухайн орны соёл, боловсролын онцлогтой уялдан хөрвүүлэгдсэн байдаг. П.Уянга миний бие 2019 онд Монголын оюутан залууст эртний хятадын уламжлалт соёл, гүн ухааны сэтгэлгээг илүү гүнзгий таньж мэдэхэд нэмэр болоосой гэсэн үүднээс “Гурван үсгийн судар”-ыг хятад хэлнээс монгол хэлнээ орчуулан тайлбарлаж, олны хүртээл болгосон билээ.

"Гурван үсгийн судар" зохиол нь өөрийн бүтэц, айзам хэмнэл, гүн гүнзгий утгатай тул орчуулахад дараах бэрхшээлүүд тулгардаг бөгөөд үүнтэй уялдсан дараах хэдэн орчуулгын онцлогтой. Үүнд:

1. Айзам, хэмнэлийг хадгалах

“Гурван үсгийн судар”-ын эх зохиол нь гурван үсэг, нэг өгүүлбэрээс бүрддэг бөгөөд энэ нь хүүхдийг цээжлэхэд хялбар болгодог. Орчуулахдаа энэхүү айзам, хэмнэлийг аль болох хадгалахыг хичээх хэрэгтэй хэдий ч бүх хэлэнд яг тэр хэв маягийг гаргах боломжгүй юм. Англи хэл дээрх орчуулгууд нь заримдаа хос мөрийн шүлгийн хэлбэр ашигладаг бөгөөд энэ нь хэмнэлийг хадгалах нэг арга юм.

2. Хүүхдийн унших дадал зуршилтай уялдуулан товч бөгөөд ойлгомжтой орчуулах.

Энэ зохиол нь хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх зохиол учир орчуулах явцад ярвигтай, хүнд хэцүү хэллэгээс зайлсхийж, аль болох товч тодорхой, хүүхэд болон анхлан суралцагчдад ойлгомжтой байх ёстой. Жишээлбэл, үгчилсэн орчуулга нь хатуу, модон санагдаж болох тул утгачилсан орчуулга нь сурган хүмүүжүүлэх ач холбогдлыг илүү сайн илэрхийлж чадна.

3. Эх зохиолын ёс суртахуун, соёлын утгыг үнэнчээр илэрхийлэх.

Уламжлалт соёлын уншлагын хувьд орчуулгын явцад Күнзийн сургаал, ёс суртахууны үзэл баримтлал, түүхэн мэдлэгийг аль болох хүргэх ёстой. Жишээлбэл, “Хүмүүн анхан төрөхөд уг чанар сайн бөлгөө. Зан чанар ойр, заншил дадал хол бөлгөө.” Чанар гэгч нь хүмүүний төрөлх чанарыг хэлж байна. Заншил дадал гэдэг нь нийгмийн зан дадлын нөлөөг хэлж буй юм. Хүн анх төрөхөд гарваль чанар угаас сайн байдаг. Олон чанар нь цөм сайн лугаа ойр байдаг. Нийгмийн үйл нөлөөллөөс болж харилцан хол болдог аж.

4. Соёлын үндэс суурийг нөхөхийн тулд тайлбарыг зохистой ашиглах

Гурван үсгийн судар зохиол нь олон янзын зүйрлэл, түүхэн хүмүүс болон хятадын уламжлалт үнэт зүйлсийг агуулсан байдаг тул уншигчдад ойлгоход нь туслах үүднээс орчуулгын явцад тайлбар нэмэх шаардлагатай болдог. Жишээлбэл, “Күн Рун дөрвөн насанд ахдаа найр тавьж, лийр өгчүхүй, ахдаан дүүчлэхүйн ёсыг анх урьдаас мэдвэл зохимуй” гэж Кун Рун лийр өгсөн түүхийг багтаасан бөгөөд үүнийг барууны уншигчид ёс суртахууны хүмүүжлийн ач холбогдлыг нь сайн ойлгохгүй байж мэдэх тул Күн Рун нь Хань улсын сүүлч үеийн хүн. Күнзийн

¹⁴ А.Даваахүү “Нэрт сайчуудын тэмдэглэл” “Гурван үсгийн судар” зохиол нь Монголын уламжлалт сургалтын эх хэрэглэгдэхүйн болох нь. УБ.1999 он

хойч үе, Гурван улсын үеийн Күнзийн сургаалтан. Тэр дөрвөн настайдаа ах дүү нартайгаа лийр идэхдээ урьдаар багыг нь авч ихийг нь ахдаан өгдөг байжээ. Дүү болох хүмүүн энэ ёсыг урьдаас мэдвэл зохимуй” хэмээн орчуулахдаа эх зохиолд зүүлт тайлбар хийх хэрэгтэй.

5. Зорилтот хэлтэй нийцсэн соёлын илэрхийлэл

“Гурван үсгийн судар” зохиол нь Күнзийн үзэл санааг их хэмжээгээр агуулсан байдаг тул шууд орчуулга нь анхны утгыг үнэн зөвөөр илэрхийлэхгүй байж болох тул орчуулахдаа тухайн хэлний соёлын онцлогийг харгалзан үзэх шаардлагатай. Жишээлбэл, домог ярианд, Хуаншян есөн настайдаа эцэг эхээ ачлахыг мэддэг байв. Өвөл болоход өөрийн биеэр эцэг эхийнхээ ор хөнжлийг дулаацуулж өгдөг, зун болоход эцэг эхийнхээ орыг өөрөө дэвүүрдэж сэрүүн болгодог байв” хэмээн Хуаншян, Вэнси хоёрын түүхийг өгүүлдэг. Энэ нь гадаадын уншигчдыг төөрөлдүүлж мэдэх тул “Өвлийн улиралд ч гэсэн эцэг эхээ ихэд хүндэтгэдэг” хэмээн эцэг эхээ ачлах сүсэг бишрэлийн үндсэн санааг товойлгон орчуулах хэрэгтэй.

Ерөнхийд нь авч үзвэл “Гурван үсгийн судар” зохиолын орчуулга нь анхны үндсэн утгатайгаа тохирч, тухайн хэлний хэллэгийн хэвшилд нийцсэн, айзам хэмнэл, соёлын онцлогийг харгалзан үзсэн байх ёстой. “Гурван үсгийн судар” зохиолыг олон хэлээр орчуулахдаа дараах арга барилаар орчуулсан байна. Үүнд:

- Үгийн тоог хадгалах (гурван үсэгтэй хэмнэлийг барих)
- Сургаал, утгыг илүү ойлгомжтой болгох
- Соёлын ялгаатай байдлыг харгалзах
- Түүхэн баримтуудыг тайлбарлах
- Орчин үеийн боловсролтой нийцүүлэх гэх мэт.

Монгол хэлний хувьд орчуулга нь богино, хэмнэлтэй, ойлгомжтой байхыг зорьдог бөгөөд уг сонголтыг үндэсний соёлтой уялдуулан орчуулсан болно.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд, “Гурван үсгийн судар” нь хүмүүний төрөлх шинж, сургах болон сурахын ач тус, юуг сурч мэдвээс зохих ертөнцийн үзэгдэл юмс зэргийг тодорхой дэс дараалалтайгаар гурав гурван ханз үсгээр бичсэн тайлбар үлгэрт гэрийн сургуулийн үндсэн сурах бичиг бөгөөд уг зохиолын сурган хүмүүжүүлэх ач холбогдол бол хүмүүжил гэдгийг суралцахын суурь үндэс гэж үзэн хүүхдийг эхийн хэвлийд байхаас нь эхлэн сургах хэрэгтэй бөгөөд багаас олсон хүмүүжил нь цаашид эрдэм номд шамдах, эцэг эхээ ачлахын үндэс болно гэж үзсэнд оршино. “Гурван үсгийн судар” зохиолын агуулгыг сурах—журмыг мэдэх—ачлах гэсэн зарчмаар томьёолж болно. Өөрөөр хэлбэл гэрийн сургуулиар олгох сургалт хүмүүжил нь хүнийг жинхэнэ хүн болгох зарчимд тулгуурлаж байжээ гэсэн үг юм.

Энэхүү зохиол нь 3 үсэгтэй шүлгийн хэлбэрээр бичигдсэн учир унших, цээжлэхэд хялбар, товч бөгөөд хүүхдэд боловсрол олгоход чиглэсэн тул дэлхийн олон орны судлаачдын сонирхлыг татаж Англи, Франц, Орос, Япон, Солонгос, Монгол, Вьетнам, Герман, Испани зэрэг хэлнээ орчуулагдсан бөгөөд эдгээр орчуулга нь тухайн орны соёл, боловсролын онцлогтой уялдан орчуулагдсан байдаг. Ерөнхийд нь авч үзвэл “Гурван үсгийн судар” зохиолын орчуулга нь анхны үндсэн утгатайгаа тохирч, тухайн хэлний хэллэгийн хэвшилд нийцсэн, айзам хэмнэл, соёлын онцлогийг харгалзан үзсэн байх ёстой.

“Гурван үсгийн судар” зохиолыг олон хэлээр орчуулахдаа үгийн тоог хадгалах (гурван үсэгтэй хэмнэлийг барих), сургаал, утгыг илүү ойлгомжтой болгох, соёлын ялгаатай байдлыг харгалзах, түүхэн баримтуудыг тайлбарлах, орчин үеийн боловсролтой нийцүүлэн уялдуулж орчуулсан байна.

"Гурван үсгийн судар" зохиол нь эртний Хятадад олон зуун жилийн турш бага насны хүүхдүүдэд уншуулдаг гол судар нь байв. Хятадын түүх, соёл, зан заншил, алдартай түүхэн хүмүүсийн талаар өгүүлсэн нь хүүхдүүдэд үндэсний бахархал, танин мэдэхүйн мэдлэг олгоод зогсохгүй ёс суртахууны хүмүүжлийн хувьд хүндлэл, энэрэл, хөдөлмөрч зан, үнэнч шударга байдал зэрэг хүний эрхэм чанаруудыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн зохиол юм.

摘要

在中国古代几千年的历程中，为儿童学习所编写的各类读物，千种万种不止。习惯上，人们把这些读物称之为“儿童启蒙读物”又称为“蒙书”。在历代启蒙读物中，使用最多、影响也最广泛的有那么几种，如《三字经》、《百家姓》、《千字文》、《千家诗》，俗称“三、百、千、千”。其中《三字经》又居首位。《三字经》的作者和写作年代，没有确切记载。一般认为它是南宋时期（1127-1279）完成的，作者是著名的学者王应麟（1223-1296）。

《三字经》的通行本，共 380 句 1140 个汉字。篇幅不长，内容非常丰富广泛，理论道德，学习方法，天地常识，典章制度，历史沿革，名人故事等，均有所涉及。

但从主题内容上看，是以道德教育为主的。文中每一层意思，都要归结到如何做人，如何成才的说教上，对被教育者寄予很大希望。

总的来看，《三字经》的翻译应符合其原文含义，应符合语言的用法、节奏和文化特征。

《三字经》翻译成多种语言时，翻译是为了保留字数（保持三个字母的节奏），使教理和意义更容易理解，考虑到文化差异，解释历史事实，并与现代教育相协调。

Ном зүй

- 1.毛增印.(2005). 三字经与中国民俗画. 中国:五洲传播出版社.
- 2.崔.额尔德木图.(2001). 汉蒙惯用语词典. 呼和浩特: 内蒙古教育出版社.
- 3.常敬宇.(2000). 汉语词汇与文化. 北京: 北京大学出版社.
- 4.仁钦道尔吉.(1998). 蒙汉熟语小词典. 呼和浩特: 内蒙古教育出版社.
- 5.武占坤、马国凡.(1991). 汉语熟语大词典. 河北: 河北教育出版社.
- 6.现代汉语词典(2002). 北京: 外语教学与研究出版社.
- 7.新蒙汉词典(1999). 北京: 商务印书馆.
- 8.朱荣阿.(1988). 蒙古族格言俗语集萃. 呼和浩特: 内蒙古人民出版社.
- 9.Адъяа, О. (1996). Ухаант ардын үнэт өв. УБ.
- 10.Аким, Г. (1988). Орчуулах эрдэм. УБ.
- 11.Базаррагчаа, Ц. (2010). Хятад Монгол хэлцийн толь. УБ.
- 12.Баянсан, Ж, Одонтөр, Ш. (1995). Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ.
- 13.Даваахүү, А. (1999). “Нэрт сайчуудын тэмдэглэл” “Гурван үсгийн судар” зохиол нь Монголын уламжлалт сургалтын эх хэрэглэгдэхүүн болох нь. УБ.
- 14.Сампилдэндэв, Х. (2004). Монгол зан үйл, аман зохиолын харьцуулсан судалгаа. УБ.
- 15.Сүхбаатар, О. (1999). Монгол хэлний харь үгийн толь. УБ.
- 16.Уянга, П. (2019). Гурван үсгийн судар. УБ.
- 17.Цэвэл, Я. (2013). Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
- 18.Чимидцээ, М. (2009). Хятадын сонгодог утга зохиолын дээж. УБ.
- 19.Чимидцээ, М. (2018). Шүүмжлэл өгүүлэл. БНХАУ: Циндао